



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/682

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а” дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019, 2020 онуудад хэрэгжсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудад хяналт, шинжилгээ үнэлэгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Цэдэнбал - Монгол Улсын гавьяат барилгачин

Ц.Давааням - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч

Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын барилгын улсын байцаагч

Нарийн бичгийн

дарга Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. 2019, 2020 оны гэрээт ажлуудыг нягтлан шалгаж дүгнэлт гарган аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/- д даалгасугай.

Zax A/682 Ch  
02 3061

3. Дээрх ажлуудад шалгалт хийхтэй холбогдон гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ